

МОНГОЛ ХЭЛ

Хувилбар: А

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Санамж: Хариултын хуудасны заавартай сайтар танилцана уу.

- Энэхүү хэсэг нь 40 сонгох даалгавар, нийт 80 оноотой.
- Даалгавар бүр 5 сонгох хариулттай бөгөөд зөвхөн нэгийг сонгоорой.
- Сонгосон хариултаа хариултын хуудсанд будаж тэмдэглээрэй.
- Эхийг анхааралтай уншиж ойлгоод, даалгаврыг гүйцэтгээрэй.
- 1-13 дугаар сорилыг эхийн утга санаатай холбон ажиллаарай.

Үр (эсээ)

Үүрийн манан татчихаад, урд уул сүндэрлэнэ үү, тал цэлийнэ үү, мэдэгдэхгүй...

Өөрөөсөө асуунам: “Уулын оройд мацаж, алсын үзүүр харах эрхэм үү, хонхрын хормой хумьж, хотгор гүдгэрийг нь нэгжих эрхэм үү?”

Дотроо бодном: “Аль алинд нь амьдын хугацаа хүрнэ гэж үү дээ? Хариу олоход хүний амьдрал ахардах ч юм шиг... Гэтэл хүний ахархан амьдрал шиг урт нь юу билээ дээ.

Наагуур бодоход, хязгааргүйн тасархай болсон хязгаар хүнийг хашна. Цаагуур бодтол, хязгааргүй нь хязгаараасаа эхэлнэ. Хязгааргүйгээсээ тасарч төрсний учир, төрсөн элгээ татан эргэж нийлэх гэж үргэлж тэмүүлнэ. Хязгаарт юм ийнхүү хязгааргүйдээ очиж, гарваль язгууртаа орох, хязгааргүйгээ тэлж нийлэх гэж тэмүүлэх үргэлжийн тэмүүлэл л амьдрал юм шиг. Алив хязгаар ч юм уу хугацаа гэдэг инээж асуухад уйлж хариулах, уйлж асуухад инээж хариулах оньсого ч юм шиг. Оньсого гэдэг инээдтэй наадам. Таалгах хүн нь инээд хүрч суухад таах хүн нь бодолд хатаж сууна. Таалгасан хүн нь таагаагүйгээ худалдана! Үг бүхэндээ хариу нь булталзаастай тааварт хүн бүдэрч “худалдагдана!”

Онсього гэдэг хариунаас нь хариулж асуусан асуулт шиг. Харин энэ амьдрал гэгч асуулт-онсього л, зохиосон хүн нь хариугаа задлалгүй өөд болчихсон орь ганц тайлал үгүй онсього шиг!... Хүн хүн дор дороо тааж, дор дороо хариу гаргаж, олсон хариуг нь хүн хүн дур дураараа няцааж, няцаахаар ч барахгүй ханцуй шамлалцаж, ханцуй шамлалцахаар ч барахгүй барилцан авч, барилцан авахаар барахгүй багалзуурдалцан зууралдаж, багалзуурдалцахаар барахгүй амь насаа юүлэлцэж, эцэс сүүлдээ эзгүй хоосонд арилах хохийн цондон татна!

Уулын оройд мацаж, алсын үзүүр ч хармаар, хонхрын хормой хумьж, хотгор гүдгэрийг нь ч нэгжмээр! Даанч хөөрхий, аугаа их амьдрал асар богино хугацаатай юм даа!

Үүрийн манан татчихаад урд уул сүндэрлэнэ үү, тал цэлийнэ үү, эс мэдэгдэнэ.

Үр биш үдэш мэт бүрий нөмрөвч үүр гэсэндээ хаяа нь тэмдгэрнэ...

Д.Урианхай

1. Эхэд буй үгсийг утгатай нь зөв тохируулаарай.

- | | |
|------------|----------------------|
| 1) цондон | а. юман дээрх хотгор |
| 2) гарваль | б. маш, тун |
| 3) хонхор | с. богино |
| 4) ахар | д. тавилан, ёр |
| 5) асар | е. анхны, үүдэл |

- A. 1b, 2e, 3a, 4c, 5d
D. 1d, 2b, 3e, 4a, 5c

- B. 1d, 2e, 3a, 4c, 5b
E. 1d, 2e, 3b, 4a, 5c

- C. 1d, 2e, 3a, 4b, 5c

2. Эсээний хөтөч санаа аль нь вэ?

- A. Үүрийн манан татчихаад, урд уул сүндэрлэнэ үү, тал цэлийнэ үү, мэдэгдэхгүй...
- B. “Уулын оройд мацаж, алсын үзүүр харах эрхэм үү, хонхрын хормой хумьж, хотгор гүдгэрийг нь нэгжих эрхэм үү?”
- C. “Аль алинд нь амьдын хугацаа хүрнэ гэж үү дээ? Хариу олоход хүний амьдрал ахардах ч юм шиг... Гэтэл хүний ахархан амьдрал шиг урт нь юу билээ дээ.
- D. Наагуур бодоход, хязгааргүйн тасархай болсон хязгаар хүнийг хашна. Цаагуур бодтол, хязгааргүй нь хязгаараасаа эхэлнэ.
- E. Уулын оройд мацаж, алсын үзүүр ч хармаар, хонхрын хормой хумьж, хотгор гүдгэрийг нь ч нэгжмээр!

3. “Онсього гэдэг хариунаас нь хариулж асуусан асуулт шиг.” толгой өгүүлбэрийг дэмжих өгүүлбэр аль вэ?

- A. Алив хязгаар ч юм уу хугацаа гэдэг инээж асуухад уйлж хариулах, уйлж асуухад инээж хариулах онсього ч юм шиг.
- B. Онсього гэдэг инээдтэй наадам. Таалгах хүн нь инээд хүрч суухад таах хүн нь бодолд хатаж сууна.
- C. Таалгасан хүн нь таагаагүйгээ худалдана! Үг бүхэндээ хариу нь булталзаастай тааварт хүн бүдэрч “худалдагдана!”
- D. Харин энэ амьдрал гэгч асуулт-онсього л, зохиосон хүн нь хариугаа задлалгүй өөд болчихсон орь ганц тайлал үгүй онсього шиг!...
- E. Хязгаарт юм ийнхүү хязгааргүйдээ очиж, гарваль язгууртаа орох, хязгааргүйгээ тэлж нийлэх гэж тэмүүлэх үргэлжийн тэмүүлэл л амьдрал юм шиг.

4. “Алив хязгаар ч юм уу хугацаа гэдэг инээж асуухад уйлж хариулах, уйлж асуухад инээж хариулах онсього ч юм шиг” хэмээсний учир юу вэ?

- A. Таалгасан хүн нь таагаагүйгээ худалддаг учраас
- B. Таалгах хүн нь инээд хүрч суухад таах хүн нь бодолд хатаж суудаг учраас
- C. Онсього гэдэг хариунаас нь хариулж асуусан асуулт шиг учраас
- D. Онсього гэдэг инээдтэй наадам учраас
- E. Үг бүхэндээ хариу нь булталзаастай тааварт хүн бүдэрч худалдагддаг учраас

5. Эсээнд дэвшүүлсэн асуудал аль нь вэ?

- A. Амьдралын мөн чанарыг таних тухай
- B. Амьдрал анх эхэлсэн цэгтээ дуусдаг тухай
- C. Хүний амьдрал тааварлашгүй байдаг тухай
- D. Хязгааргүй зүйл гэж байдаггүй тухай
- E. Амьдрал бол үл мэдэгдэх онсього шиг байдаг тухай

6. Эсээний гол санааг илэрхийлэх түлхүүр өгүүлбэрийг олоорой.

- A. Даанч хөөрхий, аугаа их амьдрал асар богино хугацаатай юм даа!
- B. Хязгаарт юм ийнхүү хязгааргүйдээ очиж, гарваль язгууртаа орох, хязгааргүйгээ тэлж нийлэх гэж тэмүүлэх үргэлжийн тэмүүлэл л амьдрал юм шиг.
- C. Харин энэ амьдрал гэгч асуулт-онсього л, зохиосон хүн нь хариугаа задлалгүй өөд болчихсон орь ганц тайлал үгүй онсього шиг!...
- D. Үүрийн манан татчихаад, урд уул сүндэрлэнэ үү, тал цэлийнэ үү, эс мэдэгдэнэ.
- E. Уулын оройд мацаж, алсын үзүүр ч хармаар, хонхрын хормой хумьж, хотгор гүдгэрийг нь ч нэгжмээр!

7. "Хүн хүн дор дороо тааж, хариу гаргаж, олсон хариуг нь хүн хүн дур дураараа няцааж, няцаахаар ч барахгүй ханцуй шамлалцаж, ханцуй шамлалцахаар ч барахгүй барилцан авч... эцэс сүүлдээ эзгүй хоосонд арилах хохийн цондон татна!" гэсэн хэсэгт зохиогч санаагаа хэрхэн гаргасан байна вэ?
- Сэтгэлийн өнгө аяс, санаагаа анхааруулан сануулсан
 - Төстэй хэлбэрээр, тэгш эрхтэйгээр зэрэгцүүлсэн
 - Санаагаа аажмаар өсгөн дүрсэлж, хүч нэмэн ахиулсан
 - Эсрэг тэсрэг санааг сөргөцүүлэн дүрсэлж харшуулсан
 - Ижил төстэй үгсийг салаавчлан бичиж сөөлжүүлсэн
8. "Таалгасан хүн нь таагаагүйгээ худалдана!" өгүүлбэрийг зөв тодорхойлоорой.
- Зэрэгцэх, угсрах холбооноос бүтсэн холимог нийлмэл өгүүлбэр
 - Тодотгол гишүүн өгүүлбэртэй угсарсан нийлмэл өгүүлбэр
 - Шууд тусагдахуун гишүүн өгүүлбэртэй угсарсан нийлмэл өгүүлбэр
 - Олон гишүүн өгүүлбэртэй угсарсан нийлмэл өгүүлбэр
 - Зэрэгцэх, харилцан угсрах холбооноос бүтсэн холимог нийлмэл өгүүлбэр
9. Аль нь хэлц өгүүлбэр вэ?
- Хүн хүн дор дороо тааж, дор дороо хариу гаргана.
 - Онъсого гэдэг хариунаас нь хариулж асуусан асуулт шиг.
 - Үүрийн манан татчихаад, урд уул сүндэрлэнэ үү, тал цэлийнэ үү.
 - Амьдрал асар богино хугацаатай юм даа.
 - Үг бүхэндээ хариу нь булталзаастай тааварт хүн бүдэрч худалдагдана.
10. "Үүрийн манан татчихаад, урд уул сүндэрлэнэ үү, тал цэлийнэ үү, эс мэдэгдэнэ." өгүүлбэрийг салаалан хувиргасан нь аль вэ?
- Үүрийн манан татчихаад, уул сүндэрлэнэ үү, тал цэлийнэ үү, эс мэдэгдэнэ.
 - Үүрийн манан татчихаад, урд тал цэлийнэ үү, уул сүндэрлэнэ үү, эс мэдэгдэнэ..
 - Үүрийн манан татчихаад, урд уул хад сүндэрлэнэ үү, тал цэлийнэ үү, эс мэдэгдэнэ.
 - Үүрийн манан татчихаад, урд уул дүнхийнэ үү, тал цэлийнэ үү, эс мэдэгдэнэ.
 - Үүрийн манан татчихаад, урд уул сүндэрлэнэ үү, тал хөндий цэлийнэ үү, эс мэдэгдэнэ.
11. "Харин энэ амьдрал гэгч асуулт-онъсого л, зохиосон хүн нь хариугаа задлалгүй өөд болчихсон орь ганц тайлал үгүй онъсого шиг" өгүүлбэр дэх "харин" хэмээх холбоос эхэд ямар утга, үүргээр орсон байна вэ?
- эсрэгцүүлэх утгыг зааж, зэрэгцүүлэн холбох үүргээр
 - онцлох утгыг зааж, эсрэгцүүлэн холбох үүргээр
 - зэрэгцүүлэх утгыг зааж, эсрэгцүүлэн холбох үүргээр
 - лавшруулах утгыг зааж, төлөөлөн холбох үүргээр
 - ялгах утгыг зааж, төлөөлөн холбох үүргээр
12. "Урд уул сүндэрлэнэ үү, тал цэлийнэ үү" нийлмэл өгүүлбэр хэрхэн холбогдсон байна вэ?
- аялгаар
 - нөхцөлөөр
 - асуух утгат үгээр
 - нөхцөл ба үгээр
 - үгийн үндсээр
13. "Таалгах хүн нь инээд хүрч суухад таах хүн нь бодолд хатаж сууна." өгүүлбэр дэх "хатаж" хэмээх үг эхэд ямар утгаар орсон байна вэ?
- санаашрах бодлогошрох
 - эргэцүүлэх тунгаах
 - зовох шаналах
 - таах таамаглах
 - эргэлзэх тээнгэлзэх
14. Бүгд дүрслэх язгуураас бүтсэн хэсгийг олоорой.
- сарталзах, цөмлөх, бувтнах
 - хагалах, цоолох, бэртэх
 - бархирах, шаржигнах, бяцлах
 - сагсалзах, угсрах, годгонох
 - сарвалзах, сунгах, лугших
15. Цэгийн оронд тохирохыг сонгоно уу.
Эш татсан зүйлд энд тэндээс орхисон бол тэрхүү орхисон газарт тавина.
- богино зураас (-)
 - цуваа цэг (...)
 - цэгтэй таслал (:)
 - давхар цэг (:)
 - таслалтай зураас (-)
16. Утгын нэгэн зүйлчлэлд хамаарах хэсгийг олоорой.
- бордоо, хөрс, цэвдэг, хлор
 - рубль, юань, фонд, евро
 - мангани, азот, магни, хүхэр
 - данс, хөрөнгө, тэгшитгэл
 - онцолбор, дэвсвэр, урвал
17. Төрөл үгээс бүрдсэн хэсгийг олоорой.
- ургамал, ургац, ургалт, ураглах
 - сэрэмж, сэргэлэн, сэргэлт, сэргэг
 - амлалт, амбан, амсар, амгай
 - бодлого, бодолт, бодгаль, бодит
 - будан, будаг, будалт, будаа
18. Үгийн сангийн онцлогоороо ялгаатай нь аль вэ?
- хэвтүүл, цэрэг, чийчаан, сүрчиг
 - намбух, улаач, шууданч, их хурал
 - алба гувчуур, оорцог, их хуралдай
 - нэгдэл, илгээлт, оточ, эмнэлэг
 - өртөө, улаа, алба, ажил, манз
19. Дараах үгсээс аль нь нутгийн аялгууны үг вэ?
- хайрхан
 - бортого
 - хөхөл
 - сийдэм
 - улаач
20. Хоёр гишүүнт бүтэцтэй холбоо үгийг олоорой.
- Эмчийн заавраар эм уух
 - Аавын бийд хүнтэй танилцах
 - Эзэн хичээвэл заяа хичээх
 - Үлгэр түүхийг анхааралтай унших
 - Хүнд хүчрийг даван туулах
21. Бүтээврийн нийлцийг зөв холбон бичсэн хэсгийг олоорой.
Ишиг тургил+**бал/вал** тэнгэр муухайрна гэж эмээ өгүүлнэ. Өвөө маань эргэн тойрон+**ыг** дурандана. Цай даргитал буц+**л+ж** байхад айлчин ирсэнд ээж баярлана.
- тургилбал, тойрныг, буцалж
 - тургилвал, тойрныг, буцалж
 - тургилбал, тойроныг, буцлаж
 - тургилвал, тойроныг, буцлаж
 - тургилбал, тойрныг, буцлаж
22. Гадаад үгэнд харьяалахын тийн ялгалын "-ийн, -ын" нөхцөлийг зөв дагуулан бичсэн хэсгийг олоорой.
- анкетын, курсийн, математикийн
 - анкетын, курсын, математикийн
 - анкетийн, курсын, математикийн
 - анкетийн, курсийн, математикийн
 - анкетын, курсийн, математикийн
23. Үгсийг утгаар нь зөв ялган бичсэнийг олоорой.
- байцай тарих, асуун байцайх
 - голын саарь, гарын сайр
 - байцаа тарих, асуун байцаах
 - голын сайр, гарын саарь
 - байцай тарих, гарын сайр
24. Ч.Лодойдамба "Алтайд" туужийн дараах хэсгүүдийн аль нь нийгмийн хам сэдвийг илтгэх вэ?
- Геологичид энэ хоёр өдрийн дотор нөгөө л цахилгаантай газрын орчим л ажилласан ба гэвч урьдахаасаа өөр юм олж үзэж чадсангүй.
 - Чингисийн цэрэг баруун тийш довтлох үед хэсэг цэрэг Алтайн нуруунд аянагд цохиулж үхсэн ба Зэв мөн тусгай баатруудыг уг газарт очуулсан нь бас үхжээ.
 - Улиастайд байсан шоронд хоёр сар гаруй болоод, хэдэн хүмүүсийн хамт оргож гараад, жингийн зам тосож, Хятадын юм дээрэмдэн явжээ.
 - Га авгай босго алхмагц зогсоод малгайгаа авч бүгдийг бөхөлзөн амарчлахад дагз дээр нь ширэлдсэн буурал гээгний тав нь модолзоно.
 - Галдан өвгөний энгэр дээр сайн малчны тэмдэг бас хэд хэдэн одон медаль гялалзана.

25. Ч.Лодойдамба “Алтайд” туужийн доорх нөхцөл байдлаас Галданг хэрхэн дүгнэж болох вэ?

Галдан бол залуудаа говийн нэртэй анчин байгаад сүүлдээ багийн дарга, нэгдлийн дарга зэрэг ажил хийгээд ан хийхээс нэлээд тасарсан хүн юм. Залуудаа бол 4-5 тэмээтэй яваад л түүндээ зээр, аргаль, янгирын мах дааж ядтал ачаад ирдэг хүн байсан юм.	Нутгийн олондоо ихээхэн хүндтэй болоод ардууд түүнийг Га авгай гэж нэрлэдэг хүн юм. Га авгай бол нэгдэлд ороод хэдэн жил болж байгаа бөгөөд одоо нэгдлийнхээ тэргүүлэгч гишүүн юм. Бас нэгдлийн тэмээ хариулах зэргээр Га авгай нэгдэлдээ чадах ядахаараа ажлаа үргэлж хийдэг хүн билээ.
--	--

- A. Ажлын арга эвийг олсон хашир туршлагатай нутгийн хүн.
- B. Алив бүх ажлыг хийж чаддаг сэргэлэн зангийнхаа ачаар амжилттай яваа хүн.
- C. Залуугаасаа нэртэй анчин байсныхаа нөлөөгөөр нэгдэлдээ тэргүүлж буй хүн.
- D. Бага залуугаасаа л нутаг усныхандаа хүндлэгдсэн төлөв төвшин хүн.
- E. Ажилч хөдөлмөрч байсныхаа ачаар үр шимийг нь хүртэж яваа хүн.

26. Ч.Лодойдамба “Алтайд” туужаас үндэсний ижилсэл буюу монгол хүний зан заншил, сэтгэл зүйн өвөрмөц онцлогийг илэрхийлсэн хэсгийг олоорой.

- A. Алтай нь манай эх орны нуруунуудын хамгийн урт нь бөгөөд хамгийн өндөр оргилтой нь юм.
- B. Дамдин “Зүрх хайрхан” гэж заахдаа долоовор хуруу нь тэнгэрийн хаяанаас нэлээд дээгүүр чиглэв.
- C. Авдрууд дээр юу ч тавиагүй бөгөөд зүүн талд нь навтгар ор зассаны өмнө элгээ хүрсэн цагаан сахалтай ханхар цээжтэй өвгөн цай ууж сууна.
- D. «Лус савдгийн буюу бурхны орон харагдаж магад, хэрэв харагдах юм бол заяа буян дэлгэрэх болно» гэж бодоод тэмээнээсээ буув.
- E. Гадаа морьдын тургих, манаанд гарсан Идэрийн хааяа хааяа исгэрэхээс өөр чимээ бас л үгүй нам гүм байлаа.

27. Б.Лхагвасүрэн “Тамгагүй төр” жүжгийн дараах хэсгүүдийн аль нь хаан төр ариун байх ёстойг харуулж байна вэ?

- A. Эгэрэг өрлөг надад хэлэхдээ
Эцгийгээ үхэхээр чи
Эхтэйгээ гэрлэнэ гэж хэлсэн
Эрхэт төрийн ёс тийм гэсэн.
- B. Хүннү төрийн тамгыг барих
Хүнгүй болчихоор нь
Хоёр сүүн уулын цаана
Хорин улаан горхины газар булчихсан.
- C. Арав алхахад найм нь алдаа
Адасга мэт араншинтай
Хүний нүд жавраар хайрсан
Хүүтэй юм байна, чи бид хоёр.
- D. Тэнгэрийн дор нэг л хаан
Өөрийнхөө он цагийг элээж
Өнгөрсөн хойно нь их орыг
Өөр нэгэн нэхдэг нь учиртай.
- E. Та бид хоёр үг таргалуулж суугаад яах вэ
Тамгаа өгчих
Сэтгэлээ барихыг хүсье
Сэнтийг чинь бол бөгс минь олоод суучихна.

28. Б.Лхагвасүрэн “Тамгагүй төр” жүжгийн хэсгийг уншаад, дотоод орчноос дүрийн сэтгэл хөдлөлийг тодорхойлоорой.

Хамгийн сүүлчийн удаа
Хаан гэдгээ мартан өлмийд чинь сөгдье.
Эцсийн удаа гишгэсэн газрын чинь
Эсгэсэн шороог би ус шиг залгилъя.

- A. сэтгэл дэнсэлсэн
- B. сэтгэл догдолсон
- C. сэтгэл нялхарсан
- D. сэтгэл уярсан
- E. сэтгэл хоргодсон

29. Б.Лхагвасүрэн “Тамгагүй төр” жүжгийн дараах хэсгээс дүрийн ямар хэв шинж илэрч байна вэ?

Эрт гундсан үзэсгэлэн чинь
Хааны дурыг гутааж
Элэгнээс чинь унасан үрд чинь
Хаан болохын заяаг дутаасан
Хяслын энэ орчлонгоос
Хариугаа би авна.

- A. эр чадалдаа эрэмшсэн
- B. дээрэлхэж бардамнасан
- C. эзлэн түрэмгийлсэн
- D. өширхөж дайсагнасан
- E. басамжлан бардсан

30. Ч.Дагвадорж “Шувуун зэл” шүлгийн

“Үдэш, орой,
Үүр цүүрээр
Үүлэн цаанаас дэв дэвсээр ганганаж
Үргэлжлэн хошуурсан шувуун зэл” хэсэгт айзам хэмнэлийг тааруулахдаа зохиогч найруулгын ямар уран хэрэглүүр ашигласан байна вэ?

- A. аажмаар өсгөн дүрсэлсэн ахиулал
- B. тэгш хэлбэрээр дүрсэлсэн зэрэгцүүлэл
- C. санааг гүнзгийрүүлэн давтсан давталт
- D. эсрэг тэсрэгийг сөргөцүүлсэн харшуулал
- E. хэлбэр өөр үгсийг сөөлжүүлсэн сөөлжүүлэл

31.

ھەممەين كۆ خەتەم ھەممەين ھەتەم ھەتەم ھەتەم ھەتەم ھەتەم ھەتەم ھەتەم ھەتەم ھەتەم ھەتەم ھەتەم ھەتەم ھەتەم ھەتەم ھەتەم	ھەممەين كۆ خەتەم ھەتەم ھەتەم ھەتەم ھەتەم ھەتەم ھەتەم ھەتەم ھەتەم ھەتەم ھەتەم ھەتەم ھەتەم ھەتەم ھەتەم ھەتەم ھەتەم
--	--

- A. Гал голомтоо дээдлэн эрхэмлэдэг тухай
- B. Гал голомтоо сахин хамгаалдаг тухай
- C. Гал голомтоо хайрлан өвлүүлдэг тухай
- D. Гал голомтоо залган мануулдаг тухай
- E. Гал голомтоо уламжлуулан өгдөг тухай

32.

ھەممەين كۆ خەتەم ھەتەم ھەتەم ھەتەم ھەتەم ھەتەم ھەтەм ھەтەм ھەтەм ھەтەм ھەтەм ھەтەм ھەтەм ھەтەм ھەтەм ھەтەм ھەтەм	ھەтەм ھەтەм ھەтەм ھەтەм ھەтەм ھەтەм ھەтەм ھەтەм ھەтەм ھەтەм ھەтەм ھەтەм ھەтەм ھەтەм ھەтەм ھەтەм ھەтەм ھەтەм ھەтەм ھەтەм
--	---

- A. ачаа зүхэх
- B. ачаа зүүх
- C. ачаа зэхэх
- D. ачаа захих
- E. ачаа зөөх

2.2. Яруу найргийн жишээг уран дүрслэлтэй нь зөв харгалзуулаарай. (a, b, c, d, e мөр бүрд нэг хариулт тааруулаарай. 1, 2, 3, 4 дугаарт байгаа нэр томъёо давхцаж болно.)

- | | |
|---|---|
| a. Нуга тойрмыг нойроос сэрээсэн
Нугасны чуулганыг битгий цочоо. | |
| b. Туулайн гүйдэл шиг салхинд
Туулын шугуй найгана. | 1. адилтгал |
| c. Ижийнхээ нүдэнд бол
Манцуйдаа тарвалзах
Мяндас цагаан хүү минь. | 2. багасгал
3. тойруулал
4. амьдчилал |
| d. Аргал, чулуу хоёрыг
Андууран түүж саналаа. | |
| e. Алаг бөмбөл эрдэнэ
Алган дээр байна гэж
Зөгнүүлж ирсэн хүү минь. | |

2.3. Жишээ үгсийг холбогдох дүрэмтэй нь харгалзуулаарай. (a, b, c, d, e мөр бүрд нэг хариулт тааруулаарай. 1, 2, 3, 4 дугаарт байгаа дүрэм давхцаж болно.)

Жишээ үгс:	Холбогдох дүрэм
a. эзэмш, үргэлж	1. Эгшигт гийгүүлэгч өмнөө юм уу хойноо аль тод хэлэгдэх талдаа заавал эгшигтэй бичигдэнэ.
b. биелнэ, тамга	2. Заримдаг гийгүүлэгч нь эгшигт гийгүүлэгчийн дараа эгшиггүй орж болно.
c. чандага, ганзага	3. Дараалсан гурван гийгүүлэгчийн гуравдугаар нь хоолойн "г", хэлний үзүүрийн "н" хоёрын нэг бөгөөд тэдгээрийн араас ялгах балархай эгшгээр үг төгсвөл "н" ба "г"-ийн өмнө богино эгшиг бичнэ.
d. жинхэнэ, ганхана	4. Дараалсан хоёр гийгүүлэгчийн хоёрдугаар нь хоолойн "г", хэлний үзүүрийн "н" хоёрын нэг байвал түүний өмнө "и"-гээс бусад балархай эгшиг бичихгүй.
e. үзвэр өгүүлбэр	

2.4. Үгсийг дүрсээр ялган, утгатай нь зөв тохируулаарай. (a, b, c, d, e мөр бүрд нэг хариулт тааруулаарай. 1, 2, 3, 4 дугаарт байгаа үгс давхцаж болно.)

- | | | | | |
|------------------|-----|-----|-----|-----|
| a. дав (даруй) | 1. | 2. | 3. | 4. |
| b. дэв (бузар) | ᠳᠦᠪ | ᠳᠡᠪ | ᠳᠦᠪ | ᠳᠡᠪ |
| c. дэв (зэрэг) | | | | |
| d. дав- (үйл үг) | | | | |
| e. дэв- (үйл үг) | | | | |

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Санамж: Хариултын хуудасны заавартай сайтар танилцана уу.

- Энэхүү хэсэг нь 40 сонгох даалгавар, нийт 80 оноотой.
- Даалгавар бүр 5 сонгох хариулттай бөгөөд зөвхөн нэгийг сонгоорой.
- Сонгосон хариултаа хариултын хуудсанд будаж тэмдэглээрэй.
- Эхийг анхааралтай уншиж ойлгоод, даалгаврыг гүйцэтгээрэй.
- 1-13 дугаар сорилыг эхийн утга санаатай холбон ажиллаарай.

Үүр (эсээ)

Үүрийн манан татчихаад, урд мэлийсэн мөрөн урсана уу, мэлтэгнэсэн булаг урсана уу, мэдэгдэхгүй...

Өөрөөсөө асуунам: “Ширгэж хатдаг ч гэлээ ангаж туйлдаад очиход амны цангаа тайлахуйцаар ундраад өгдөг булаг эрхэм үү, цаг хамаагүй мэлийж мэлтийж байдаг мөртөө цангаж туйлдаад очиход санаандгүй нэг ширгэчихсэн байх магадгүй гол эрхэм үү?”

Дотроо бодном: “Аль аль нь ч адилхан л тусаа өгсөн ус бус уу? Ангаж үхдэгийн даваан дээр очиход ширгэчихсэн байх гол нь гэхэд, урьд нь олон удаа аминд орсон байж болох бус уу? Ангаж үхүүлэхгүй нь лавтай булаг нь гэхэд, аль орон хэрэгтэй бусад цагт хуурай байсан байж болох бус уу? Адилыг нь хэлбэл адил, ялгааг нь хэлбэл ялгаатай юм бус уу? Адилын ялгаанд л Амьдрал-оньсогоны тайлал лацдаастай байдаг юм биш биз? Цагийн туурайд үрэгдэх, үлдэх хоёрын ялгаанд л хүний амьд явсан хугацаа амьдрал мөн байсан, биш байсны зөрөө нуугдаастай байдаг юм биш биз?”

Үрээд өнгөрдөг нь ч цагийн туурай, үлдээгээд өгдөг нь ч цагийн туурай! Үүсгэж-устгаж, элээж-шинэдээж, байгаа атлаа байхгүйн адил орших энэ цагийн туурай л хязгааргүйн доторх хязгаар.

Нарны гэрэл бэлчих дотор хоёрхон юм үнэн.

- Цагийн туурай дайран, хязгаар хэмэндээ хаших үнэн.
- Цагийн туурай дайран, хязгааргүйн хэмэнд аваачих үнэн.

Харин цагийн цаана юу бий бол? Эхлэх үү, “эцэслэх үү?” Нарны цаана юу бий бол? Гэгээ юу, харанхуй юу?

Үүрийн манан татчихаад, урд мөрөн мэлийнэ үү, булаг мэлтэгнэнэ үү, мэдэгдэхгүй.

Үүр биш үдэш мэт бүрий нөмрөвч үүр гэсэндээ хаяа нь тэмдгэрнэ...

Д.Урианхай

1. Эхэд буй үгсийг утгатай нь зөв тохируулаарай.

- | | |
|--------------|-------------------|
| 1) элээх | a. хорих тогтоох |
| 2) шинэдээх | b. битүүмжлэх |
| 3) хаших | c. үүр цайж эхлэх |
| 4) тэмдгэрэх | d. хуучруулах |
| 5) лацдах | e. шинэ болгох |

- A. 1d, 2e, 3a, 4b, 5c
D. 1d, 2e, 3b, 4a, 5c

- B. 1d, 2e, 3a, 4c, 5b
E. 1e, 2d, 3c, 4a, 5b

- C. 1d, 2e, 3b, 4c, 5a

2. Эсээний хөтөч санаа аль нь вэ?

- A. Үүрийн манан татчихаад, урд мэлийсэн мөрөн урсана уу, мэлтэгнэсэн булаг урсана уу, мэдэгдэхгүй...
- B. Ангаж үхдэгийн даваан дээр очиход ширгэчихсэн байх гол нь гэхэд, урьд нь олон удаа аминд орсон байж болох бус уу? Ангаж үхүүлэхгүй нь лавтай булаг нь гэхэд, аль орон хэрэгтэй бусад цагт хуурай байсан байж болох бус уу?
- C. Ширгэж хатдаг ч гэлээ ангаж туйлдаад очиход амны цангаа тайлахуйцаар ундраад өгдөг булаг эрхэм үү, цаг хамаагүй мэлийж мэлтийж байдаг мөртөө цангаж туйлдаад очиход санаандгүй нэг ширгэчихсэн байх магадгүй гол эрхэм үү?
- D. Цагийн туурайд үрэгдэх, үлдэх хоёрын ялгаанд л хүний амьд явсан хугацаа амьдрал мөн байсан, биш байсны зөрөө нуугдаастай байдаг юм биш биз?
- E. Нарны гэрэл бэлчих дотор хоёрхон юм үнэн.
Цагийн туурай дайран, хязгаар хэмэндээ хаших үнэн.
Цагийн туурай дайран, хязгааргүйн хэмэнд аваачих үнэн.

3. “Аль аль нь ч адилхан л тусаа өгсөн ус бус уу?” толгой өгүүлбэрийг дэмжих өгүүлбэр аль вэ?

- A. Цагийн туурай дайран, хязгаар хэмэндээ хаших үнэн.
- B. Нарны гэрэл бэлчих дотор хоёрхон юм үнэн.
- C. Нарны цаана юу бий бол? Гэгээ юу, харанхуй юу?
- D. Адилыг нь хэлбэл адил, ялгааг нь хэлбэл ялгаатай юм бус уу?
- E. Үүрийн манан татчихаад, урд мөрөн мэлийнэ үү.

4. Хүний амьд явсан хугацаа амьдрал мөн байсан, биш байсны зөрөө юунд нуугдаастай байна вэ?

- A. Үрэгдэх, үлдэх хоёрын ялгаанд
- B. Адилын адил, ялгаатайн ялгаанд
- C. Байгаа атлаа байхгүйн адил орших энэ цагт
- D. Үлдээгээд өгдөг цагийн туурайд
- E. Үрээд өнгөрдөг цагийн туурайд

5. Эсээнд дэвшүүлсэн асуудал аль нь вэ?

- A. Цаг хугацаа бүхний шалгуур байдаг тухай
- B. Хязгааргүй зүйл гэж байдаггүй тухай
- C. Амьдрал анхны цэгтээ эргэж дуусдаг тухай
- D. Хүний амьдрал тааварлашгүй байдаг тухай
- E. Илүү зүйл гэж хорвоод байдаггүй тухай

6. Эсээний гол санааг илэрхийлэх түлхүүр өгүүлбэрийг олоорой.

- A. Нарны гэрэл бэлчих дотор хоёрхон юм үнэн.
- B. Байгаа атлаа байхгүйн адил орших энэ цагийн туурай л хязгааргүйн доторх хязгаар.
- C. Харин цагийн цаана юу бий бол? Эхлэх үү, “эцэслэх үү?” Нарны цаана юу бий бол? Гэгээ юу, харанхуй юу?
- D. Үүрийн манан татчихаад, урд мөрөн мэлийнэ үү, булаг мэлтэгнэнэ үү, мэдэгдэхгүй.
- E. Үрээд өнгөрдөг нь ч цагийн туурай, үлдээгээд өгдөг нь ч цагийн туурай!

7. “Ангаж үхдэгийн даваан дээр очиход ширгэчихсэн байх гол нь гэхэд, урьд нь олон удаа аминд орсон байж болох бус уу? Ангаж үхүүлэхгүй нь лавтай булаг нь гэхэд, аль орон хэрэгтэй бусад цагт хуурай байсан байж болох бус уу?” гэсэн хэсэгт зохиогч санаагаа хэрхэн гаргасан байна вэ?

- A. Сэтгэлийн өнгө аяс, санаагаа анхааруулан сануулсан
- B. Санаагаа аажмаар өсгөн дүрсэлж, хүч нэмэн ахиулсан
- C. Төстэй хэлбэрээр, тэгш эрхтэйгээр зэрэгцүүлсэн
- D. Эсрэг тэсрэг санааг сөргөцүүлэн дүрсэлж харшуулсан
- E. Ижил төстэй үгсийг салаавчлан бичиж сөөлжүүлсэн

8. “Туйлдаад очиход санаандгүй нэг ширгэчихсэн байх магадгүй гол эрхэм үү?” өгүүлбэрийг зөв тодорхойлоорой.
- A. Байц гишүүн өгүүлбэртэй угсарсан нийлмэл өгүүлбэр
 B. Тодотгол гишүүн өгүүлбэртэй угсарсан нийлмэл өгүүлбэр
 C. Олон гишүүн өгүүлбэртэй угсарсан нийлмэл өгүүлбэр
 D. Зэрэгцэх, угсрах холбооноос бүтсэн холимог нийлмэл өгүүлбэр
 E. Зэрэгцэх, харилцан угсрах холбооноос бүтсэн холимог нийлмэл өгүүлбэр
9. Аль нь хэлц өгүүлбэр вэ?
- A. Үүрийн манан татчихаад, урд мөрөн мэлийнэ үү.
 B. Нарны гэрэл бэлчих дотор хоёрхон юм үнэн.
 C. Мэлтэгнэсэн булаг урсана уу, мэдэгдэхгүй...
 D. Ангаж үхүүлэхгүй нь лавтай булаг.
 E. Адилыг нь хэлбэл адил, ялгааг нь хэлбэл ялгаатай.
10. “Үүрийн манан татчихаад, урд мөрөн мэлийнэ үү, булаг мэлтэгнэнэ үү, мэдэгдэхгүй.” өгүүлбэрийг салаалан хувиргасан нь аль вэ?
- A. Үүрийн манан татчихаад, мөрөн мэлийнэ үү, булаг мэлтэгнэнэ үү, мэдэгдэхгүй.
 B. Үүрийн манан татчихаад, урд гол мөрөн мэлийнэ үү, булаг мэлтэгнэнэ үү, мэдэгдэхгүй.
 C. Үүрийн манан татчихаад, урд мөрөн мэлийнэ үү, булаг цэлэлзэнэ үү, мэдэгдэхгүй.
 D. Үүрийн манан татчихаад, урд булаг мэлтэгнэнэ үү, мөрөн мэлийнэ үү, мэдэгдэхгүй.
 E. Үүрийн манан татчихаад, урд мөрөн мэлийнэ үү, булаг шанд мэлтэгнэнэ үү, мэдэгдэхгүй.
11. Дараах өгүүлбэрийн “харин” хэмээх холбоос эхэд ямар утга, үүргээр орсон байна вэ?
 Харин цагийн цаана юу бий бол? Эхлэх үү, “эцэслэх үү?”
- A. онцлох утгыг зааж, эсрэгцүүлэн холбох үүргээр
 B. зэрэгцүүлэх утгыг зааж, эсрэгцүүлэн холбох үүргээр
 C. лавшруулах утгыг зааж, төлөөлөн холбох үүргээр
 D. эсрэгцүүлэх утгыг зааж, зэрэгцүүлэн холбох үүргээр
 E. ялгах утгыг зааж, төлөөлөн холбох үүргээр
12. “Урд мөрөн мэлийнэ үү, булаг мэлтэгнэнэ үү” нийлмэл өгүүлбэр хэрхэн холбогдсон байна вэ?
- A. аялгаар
 B. нөхцөлөөр
 C. асуух утгат үгээр
 D. нөхцөл ба үгээр
 E. үгийн үндсээр
13. “Нарны гэрэл бэлчих дотор хоёрхон юм үнэн.” өгүүлбэр дэх “бэлчих” хэмээх үг эхэд ямар утгаар орсон байна вэ?
- A. тархах хамрах
 B. тусах гэрэлтэх
 C. орших байх
 D. түгэх дэлгэрэх
 E. бүрхэх нөмрөх
14. Бүгд дүрслэх язгуураас бүтсэн хэсгийг олоорой.
- A. арзайх, шоржигнох, түгших
 B. хугалах, цоорох, гэмтэх
 C. хархирах, харжигнах, няцлах
 D. сортолзох, нүдлэх, дангинах
 E. гэдийх, сийчих, мэлтийх
15. Цэгийн оронд тохирохыг сонгоно уу.
 Өгүүлэгчийн сандарсан, түгдэрсэн байдлыг илэрхийлэхдээ тавина.
- A. давхар цэг (:)
 B. богино зураас (-)
 C. цэгтэй таслал (;)
 D. цуваа цэг (...)
 E. таслалтай зураас (-, -)
16. Утгын нэгэн зүйлчлэлд хамаарах хэсгийг олоорой.
- A. хурд, хүч, чадал, магадлал
 B. доллар, иен, бонд, фунт
 C. хромосом, ген, эс, бөөм
 D. арилжаа, нийлүүлэлт, үүсвэр
 E. орлуулал, цээрлэл, нэгдэл
17. Төрөл үгээс бүрдсэн хэсгийг олоорой.
- A. зорц, зоргол, зорогч, зоруул
 B. үзвэр, үзэмж, үзүүр, үзлэг
 C. эрчим, эрэлхэг, эрэгчин, эрэл
 D. ухаан, ухааж, ухаарал, ухвар
 E. зогсоо, зогсоц, зогьсолт
18. Үгийн сангийн онцлогоороо ялгаатай нь аль вэ?
- A. хамтрал, атрын аян, нөхөр
 B. богц, багц, ариутган шүүгч
 C. их хориг, өртөө, гүнцэг, зоог
 D. дэн буудал, тойн, лагшин
 E. оточ, манцуй, хувилахуй ухаан
19. Дараах үгсээс аль нь нутгийн аялгууны үг вэ?
- A. боохой
 B. богц
 C. жас
 D. гос
 E. зайран
20. Хоёр гишүүнт бүтэцтэй холбоо үгийг олоорой.
- A. Эрхийг сурахаар бэрхийг сурах
 B. Агтны бийд газар үзэх
 C. Улс төрд хүчин зүтгэх
 D. Сонин сэтгүүлээ хурдан хэвлэх
 E. Багшийн заавраар хичээл давтах
21. Бүтээврийн нийлцийг зөв холбон бичсэн хэсгийг олоорой.
 Амьтан+ы орогнох оромжийг үүр гэж ерөнхийд нь нэр+л+дэг. Ойд байх олон сая шоргоолж зөөлөн шороог бөмбийл+вөл/бөл үүрээ зассаны шинж.
- A. Амьтаны, нэрлэдэг, бөмбийлбөл
 B. Амьтны, нэрлэдэг, бөмбийлбөл
 C. Амьтаны, нэрэлдэг, бөмбийлвөл
 D. Амьтны, нэрлэдэг, бөмбийлвөл
 E. Амьтны, нэрэлдэг, бөмбийлбөл
22. Гадаад үгэнд харьяалахын тийн ялгалын “-ийн, -ын” нөхцөлийг зөв дагуулан бичсэн хэсгийг олоорой.
- A. клубын, брокерын, тактикийн
 B. клубийн, брокерын, тактикийн
 C. клубийн, брокерийн, тактикийн
 D. клубын, брокерийн, тактикийн
 E. клубийн, брокерын, тактикийн
23. Үгсийг утгаар нь зөв ялган бичсэнийг олоорой.
- A. хойд тууль, үлгэр туйл
 B. хойд туйл, үлгэр тууль
 C. хүрзний эш, иш татах
 D. хүрзний иш, иш татах
 E. эш татах, хойд тууль
24. Д.Цэдэв “Улаан хамбан зодогт буюу тавын даваа” туужийн дараах хэсгүүдийн аль нь нийгмийн хам сэдвийг илтгэх вэ?
- A. Зуны зоосон шар наран Сонгино хайрханы цаагуур далд орох завдан, наадмын талбайд энэ өдрийн сүүлчийн гэрлээ харамгүй цацрааж байв.
 B. Наадмын талбайн баруун зүүн жигүүрт эрээлэн ханхайх монгол үндэсний угалз мэтгэсэн асрууд харагдана.
 C. Улс даяар «Босоо» гэж алдаршсан суут бөхийн хоч чимгийг барилдахын өмнө дуулаагүй нь ямаай.
 D. Энэ чинь хуучин Сайн ноён ханы Насан арслантай гараа дэвээ нь яасан адилхан юм бэ! гэж нүдэндээ итгэж ядсан нэгэн өвгөн өгүүлнэ.
 E. 1821 оны үеэс Дорнодын талд нар, салхи амсан байж, чийрэг боргил өссөн Хүдэр гэдэг хүү айл айлд ачаа тээшний хүндийг өргөн зарцлагдаж явсан юм гэнэ билээ.

33. 34. 35. 36. 37.

<<төгөөх>> үгийг
 үгэнд нь оруулж
 өгөгдсөн үгсийн дунд
 зөв хариултыг сонгоно.

- A. үгс
- B. үг
- C. үгс
- D. үг
- E. үгс

Хүн хүнийг үл хангалуулж
 үл хангалуулж
 үл хангалуулж
 үл хангалуулж
 үл хангалуулж

Эрхэ баг-а
 насун
 даган
 дүрсү үгэи
 буу зангна.

- A. үгс
- B. үгс
- C. үгс
- D. үгс
- E. үгс

Хүн хүнийг үл хангалуулж
 үл хангалуулж
 үл хангалуулж
 үл хангалуулж
 үл хангалуулж

- A. үгс
- B. үгс
- C. үгс
- D. үгс
- E. үгс

Хүн хүнийг үл хангалуулж
 үл хангалуулж
 үл хангалуулж
 үл хангалуулж
 үл хангалуулж

Хүн хүнийг үл хангалуулж
 үл хангалуулж
 үл хангалуулж
 үл хангалуулж
 үл хангалуулж

- A. Харилцан үйлдэлдэх хэв
- B. Бусдын эрхэнд үйлдэгдэх хэв
- C. Хамтран үйлдэлцэх хэв
- D. Бусдаар үйлдүүлэх хэв
- E. Өөрөө үйлдэх хэв

38. 39. 40.

<<төгөөх>> үгийг
 үгэнд нь оруулж
 өгөгдсөн үгсийн дунд
 зөв хариултыг сонгоно.

- A. үгс
- B. үг
- C. үгс
- D. үг
- E. үгс

- A. үгс
- B. үгс
- C. үгс
- D. үгс
- E. үгс

- A. үгс
- B. үгс
- C. үгс
- D. үгс
- E. үгс

ХОЁРДУГААР ХЭСЭГ

Санамж:

- Энэ хэсэг нь 4 даалгавар, нийт 20 оноотой.
- Сонгох даалгавар биш тул харгалзааг зөв тогтоож, тохирох хариуг будаарай.
- Зөв харгалзуулсан хариулт бүр 1 оноотой.

2.1. Жишээ өгүүлбэрийг нэр томъёотой нь зөв харгалзуулаарай. (a, b, c, d, e мөр бүрд нэг хариулт тааруулаарай. 1, 2, 3, 4 дугаарт байгаа нэр томъёо давхцаж болно.)

- | | |
|------------------------------------|-------------------------------------|
| a. Өвгөн Жалбуу өөрөө уудална. | 1. Нэг бүрэлдэхүүнт цөм өгүүлбэр |
| b. Уулсын цаанаас наран мандана. | 2. Хоёр бүрэлдэхүүнт цөм өгүүлбэр |
| c. Зуншив. | 3. Гурван бүрэлдэхүүнт цөм өгүүлбэр |
| d. Түргэн явах хэрэгтэй боллоо. | 4. Цөм бус өгүүлбэр |
| e. Ононы урсгал мэлтийн цэлэлзэнэ. | |

2.2. Яруу найргийн жишээг уран дүрслэлтэй нь зөв харгалзуулаарай. (a, b, c, d, e мөр бүрд нэг хариулт тааруулаарай. 1, 2, 3, 4 дугаарт байгаа нэр томъёо давхцаж болно.)

- | | |
|--|--------------|
| a. Уулын согоо шиг хүүхэнд
Хайрын сэтгэл дасна. | |
| b. Олонцог элээгээгүй дэгдээхэй насандаа би чинь
Оготно бор толгодоо уул гэж эндүүрч явжээ. | 1. адилтгал |
| c. Газрын хөх судас бүдэг бадагхан цохилно
Гал дундуур урсах мэт бөг бөг шогшино. | 2. багасгал |
| d. Ижий нь хүүгээ
Их санах юм даа
Араг, савар хоёроо
Зөрүүлэн байж бодлоо. | 3. тойруулал |
| e. Тэнгэр эцгийнхээ зүүрмэглэх зуур
Тэрхэн зуурын зүүд болж
Газар дэлхий дээр ирсэн юм. | 4. амьдчилал |

2.3. Жишээ үгсийг холбогдох дүрэмтэй нь харгалзуулаарай. (a, b, c, d, e мөр бүрд нэг хариулт тааруулаарай. 1, 2, 3, 4 дугаарт байгаа дүрэм давхцаж болно.)

Жишээ үгс:	Холбогдох дүрэм
a. хагд, урамш	1. Эгшигт гийгүүлэгч өмнөө юм уу хойноо аль тод хэлэгдэх талдаа заавал эгшигтэй бичигдэнэ.
b. хундага, чагтага	2. Заримдаг гийгүүлэгч нь эгшигт гийгүүлэгчийн дараа эгшиггүй орж болно.
c. аялна, торго	3. Дараалсан гурван гийгүүлэгчийн гуравдугаар нь хоолойн "г", хэлний үзүүрийн "н" хоёрын нэг бөгөөд тэдгээрийн араас ялгах балархай эгшгээр үг төгсвөл "н" ба "г"-ийн өмнө богино эгшиг бичнэ.
d. цацрал, хөдөлмөр	4. Дараалсан хоёр гийгүүлэгчийн хоёрдугаар нь хоолойн "г", хэлний үзүүрийн "н" хоёрын нэг байвал түүний өмнө "и"-гээс бусад балархай эгшиг бичихгүй.
e. эрдэнэ, бүрхэнэ	

2.4. Үгсийг дүрсээр ялган, утгатай нь зөв тохируулаарай. (a, b, c, d, e мөр бүрд нэг хариулт тааруулаарай. 1, 2, 3, 4 дугаарт байгаа үгс давхцаж болно.)

- | | | | | |
|----------------|----|----|----|----|
| a. зэв (төмөр) | 1. | 2. | 3. | 4. |
| b. зэв (сүм) | ᠵ | ᠵ | ᠵ | ᠵ |
| c. зав (чөлөө) | | | | |
| d. зав (уулын) | | | | |
| e. жив (хов) | | | | |

№	А хувилбар	В хувилбар
	Зөв хариу	Зөв хариу
1	B	B
2	C	C
3	D	D
4	E	A
5	A	A
6	A	E
7	C	D
8	D	C
9	E	B
10	D	C
11	A	D
12	A	A
13	C	A
14	D	E
15	B	D
16	C	C
17	B	D
18	C	E
19	D	D
20	E	C
21	A	B
22	A	B
23	D	B
24	C	E
25	E	B
26	D	E
27	B	A
28	C	E
29	D	A
30	A	D

31	A	E
32	E	D
33	D	C
34	C	A
35	A	E
36	E	D
37	D	C
38	C	B
39	A	D
40	E	E
2.1	a1	a3
	b2	b4
	c4	c1
	d4	d4
	e3	e2
2.2	a4	a1
	b1	b2
	c2	c4
	d3	d3
	e3	e3
2.3	a2	a2
	b4	b3
	c3	c4
	d3	d1
	e1	e3
2.4	a1	a1
	b1	b2
	c3	c3
	d2	d2
	e4	e4